



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А173

Сангийндалай

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, "Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль"-ийн 9 дүгээр зүйлийн 9.4-9.8, дахь дэх заалт, Засгийн газрын 2023 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 10 дугаар хурлын тэмдэглэл Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/02 дугаар тушаал Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/87 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 25 хоногийн хугацаанд гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын тов мэдээг малчид, мал бүхий иргэдэд хүргэн, бэлэн байдлыг хангуулж үхэр сүргийг бүрэн хамруулахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Малчид мал бүхий иргэдэд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын мэдээлэл хүргэн бэлэн байдлыг хангуулж төлөвлөгөөт үхрийг бүрэн хамруулж ажиллахыг Хөдөө аж ахуйн тасаг, багийн Засаг дарга нар, Мал эмнэлгийн Тархвар зүйч (Т.Машбат) нарт үүрэг болгосугай.

3. Дархлаажуулалтыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж шуурхай үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг мал эмнэлгийн Тархвар зүйч (Т.Машбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ О.БАЗАРРАГЧАА



482302145